

НИЙСЛЭЛИЙН ДОТООД АУДИТЫН АЛБА



АУДИТ, ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН УДИРДАМЖ

2025 он

БАТЛАВ
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ Х.НЯМБААТАР

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН УДИРДАМЖ

№ 08

2025 оны 03 сарын 13 өдөр

Улаанбаатар хот

Санхүүгийн хяналт шалгалтад хамрагдах байгууллагын нэр

Нийслэлийн Дотоод аудитын албаны Аудит хяналт шалгалтын 2025 оны төлөвлөгөөнд тусгагдсан байгууллагууд.

Нэг. Нийтлэг үндэслэл

Монгол Улсын Төсвийн тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”, нийслэлийн Дотоод аудитын албаны Аудит хяналт шалгалтын 2025 оны төлөвлөгөөний дагуу санхүүгийн хяналт шалгалтыг хийж дүгнэлт өгөх, цаашид үүсэх эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд оршино.

Хоёр. Хяналт шалгалтын зорилго

Хяналт шалгалтад хамрагдах байгууллагын үйл ажиллагаа нь төсөв, санхүү, өмч хөрөнгөтэй холбоотой Монгол Улсын хууль тогтоомж, түүнд нийцүүлэн төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан заавар, журамтай нийцэж буй эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөх, мэргэжил, арга зүйн зөвлөгөөгөөр хангахад оршино.

Гурав. Хяналт шалгалтын цар хүрээ

Санхүүгийн хяналт шалгалтад дараах үйл ажиллагааг хамруулна. Үүнд:

- Санхүү, төсөв, өмч, нягтлан бодох бүртгэлийн холбогдолтой хууль, тогтоомж, түүнийг үндэслэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан заавар, журмын хэрэгжилт;
- Байгууллагын дотоод журам, удирдлагын тушаал, бусад байгууллага хувь хүнтэй байгуулсан гэрээ, хэлцэл нь хууль эрх зүйн үндэслэлтэй хийгдсэн эсэх, тэдгээрийн хэрэгжилт;
- Батлагдсан төсөв түүний зарцуулалт, өөрийн орлогын төлөвлөгөө биелэлтийн байдал;
- Тус байгууллагын бүтэц орон тоо, цалин хөлсний тогтоолт, олгосон байдал;
- Өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, зарцуулалт, олж бэлтгэсэн байдал, тооллого, тооцоо бодолт;
- Санхүүгийн үйл ажиллагааны үр дүн, үр ашгийн байдал;
- Дээд шатны төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэг, түүний зарцуулалт;

- Тусгай сангуудын төлөвлөлт, зарцуулалт
- Хандив тусламжийн хөрөнгө түүний зарцуулалт
- Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, баримтын бүрдүүлэлт, боловсруулалт, санхүүгийн мэдээ, тайлан гаргалтын байдал;
- Гадаад, дотоодын байгууллага, иргэдээс өгсөн зээл, тусламжийн хөрөнгийн зарцуулалт, ашиглалтын байдал;
- Татвар, нийгмийн даатгалын шимтгэл, ноогдол ашиг зэрэг төсөвт төвлөрүүлэх төлбөрийн төвлөрүүлэлтийн байдал;
- Байгууллагын авлага, өр төлбөрийн үүссэн байдал, барагдуулалт, тооцоо нийлсэн актаар баталгаажсан эсэх;
- Худалдан авах үйл ажиллагааны төлөвлөгөө, хэрэгжилт, түүнтэй холбоотой үйл ажиллагааны гүйцэтгэл;
- Хөрөнгө оруулалтын ашиглалт, зарцуулалт;
- Хөрөнгө оруулалтын ажлуудын гэрээ, биелэлт;
- Өмнө хийгдсэн шалгалт, акт, албан шаардлага, зөвлөмжийн барагдуулалт зэргийг хамруулан шалгана.

Дөрөв. Санхүүгийн хяналт шалгалтын бүрэлдэхүүн

Санхүүгийн хяналт шалгалтыг нийслэлийн Дотоод аудитын албаны Аудит, хяналт шалгалтын хэлтсийн ахлах дотоод аудиторуд гүйцэтгэнэ.

Тав. Санхүүгийн хяналт шалгалтын явцад хийх ажил

Шалгалтын үеэр гарсан санал хүсэлт, өргөдөл, гомдлыг хүлээн авч, шалган хариу өгөх, шалгалтын дүн мэдээнд оруулах;

- Хандив тусламжийн орлого, түүний зарцуулалтад хяналт хийх;
- Байгууллагын өмч хөрөнгийн ашиглалт, хамгаалалт, байршилтай газар дээр нь танилцах, хэсэгчилсэн тооллого хийх;
- Өмнөх санхүүгийн шалгалтаар илэрсэн зөрчил, актаар хүлээлгэсэн төлбөрийг хэрхэн барагдуулсан талаар үзэж, үлдэгдэл төлбөрийг бүрэн барагдуулах;
- Тухайн байгууллагын харьяалагдах дээд шатны болон бусад байгууллагын үйл ажиллагаатай холбоотой зайлшгүй шийдвэрлэх асуудал гарвал холбогдох газарт нь хандаж шийдвэрлүүлэх.

Зургаа. Үүрэг, хариуцлага

Хяналт шалгалтад хамрагдаж буй байгууллага:

- Шаардлагатай тайлан мэдээ, тушаал шийдвэр, санхүүгийн баримт материал болон бусад шаардлагатай материалыг шаардсан хугацаанд саадгүй гаргаж өгөх;
- Хяналт шалгалтын явцад холбогдох программ хангамжид нэвтрэн шалгалт хийх нөхцөл бололцоогоор хангах;
- Шалгалтын тайлангийн төсөлтэй танилцаж санал, тайлбар өгөх.

Хяналт шалгалт хийх баг:

- Удирдамжийн хүрээнд ажиллах;

- Хяналт шалгалтын ажлын явцад хамрагдаж буй байгууллага, хувь хүний хуулиар хамгаалагдсан мэдээллийн нууцлалыг хадгалах;
- Шалгалтыг холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын дагуу хийж гүйцэтгэх.

Долоо. Санхүүгийн хяналт шалгалтын үр дүнг, тайлагнах зарчим

- Санхүүгийн хяналт шалгалтын баг нь албаны удирдлага болон хариуцсан нэгжийн даргыг дотоод аудит, хяналт шалгалтын явцын талаар мэдээллээр хангаж ажиллана.
- Шалгалтын талаар тайлан, акт, албан шаардлагыг бичиж шалгуулсан этгээдэд танилцуулж, гарын үсгээр баталгаажуулна.
- Шалгалтаар илэрсэн асуудлыг нийслэлийн Дотоод аудитын хорооны хурлаар хэлэлцүүлэн холбогдох шийдвэрийг гаргуулна.
- Хяналт шалгалтын тайлан, акт, албан шаардлага, тоо баримтын үндэслэл нотолгооны үнэн зөвийг багийн ахлагч, гишүүд хариуцна.

ХЯНАСАН:
НИЙСЛЭЛИЙН ДОТООД АУДИТЫН
АЛБАНЫ ДАРГА

БОЛОВСРУУЛСАН:
АУДИТ, ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ХЭЛТСИЙН
АХЛАХ ДОТООД АУДИТОР



З.ОТГОНБАЯР

Д.НАНСАЛМАА

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
05-Р УДИРДАМЖИЙН ХАВСРАЛТ

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН БАГ

№	Байгууллагын нэр	Багийн гишүүн	Хугацаа	Хамрагдах хугацаа (он)
1	Нийслэлийн Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газар	Д.Лувсанчимэд Ц.Дуламдорж Б.Отгонтуяа	2025.04.28-ны өдрөөс ажлын 15 хоног	2023, 2024 он
2	Нийслэлийн Агаар орчны бохирдолтой тэмцэх газар	Д.Мөнхханд Г.Баярмаа	2025.05.08-ны өдрөөс ажлын 22 хоног	2023, 2024 он

НИЙСЛЭЛИЙН ДОТООД АУДИТЫН АЛБА

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТАЙЛАН

Хяналт шалгалтын нэр: 2023, 2024 оны санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалт

Хамрагдсан байгууллага: Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газар

Улаанбаатар хот
2025 он

АГУУЛГА

ТАНИЛЦУУЛГА	4
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ХАМРАХ ХҮРЭЭ	4
<i>Үндсэн үйл ажиллагаа</i>	<i>...</i>
<i>Санхүүгийн үйл ажиллагаа</i>	<i>8</i>
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ, ДУТАГДЛЫН ТАЛААР	8
ДҮГНЭЛТ	20
ЗӨВЛӨМЖ	20

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
НЗД	Нийслэлийн Засаг дарга
НХААГ	Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар
НДАА	Нийслэлийн дотоод аудитын алба
НЗДТГ	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримт
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
НББ	Нягтлан бодох бүртгэл
БОАЖЯ	Байгаль, Орчин аялал жуулчлалын яам
НАОБТГ	Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХАА	Худалдан авах ажиллагаа
ТББ	Төрийн бус байгууллага
НӨХГ	Нийслэлийн өмчийн харилцааны газар
НИТХ	Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НАБТГ	Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газар
АҮТХ	Ажил үйлчилгээний төлбөр хураамж
БХХ	Бодлогын хэрэгжилтийн хэлтэс
АЧХЗБХ	Агаарын чанарын хэмжилт зохион байгуулалтын хэлтэс
ХАБЭА	Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ШТС	Шатахуун түгээх станц

ТАНИЛЦУУЛГА

Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газар нь анх 2006 оны 10 дугаар сард Нийслэлийн Засаг даргын 444 дүгээр захирамжаар Нийслэлийн Байгаль хамгаалах газрын дэргэд 7 албан хаагчийн бүрэлдэхүүнтэй “Агаарын чанарын алба” нэртэйгээр байгуулагдсан. Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн 68 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 14 дүгээр захирамжаар 16 албан хаагч, 2013 онд Нийслэлийн Засаг даргын А/75 дугаар тогтоолоор 3 хэлтэс бүхий 26 албан хаагч, Засгийн газрын 2016 оны 8 дугаар тогтоолоор 3 хэлтэс бүхий 20 албан хаагчийн бүрэлдэхүүнтэй “Агаарын бохирдлыг бууруулах газар”, Засгийн газрын 2019 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн 100 дугаар тогтоолоор “Агаарын бохирдолтой тэмцэх газар” болж, 3 хэлтэс, 24 албан хаагч, НЗД-ын 2019 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн А/1236 дугаар захирамжаар Бодлогын хэрэгжилтийн хэлтэст 15 диспетчерийн орон тоог нэмж, 39 албан хаагч, 2021 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/1037 дугаар захирамжаар Агаар, орчин бохирдолтой тэмцэх газар болж өөрчлөгдсөн.

НЗД-ын 2023 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн “Дүрэм шинэчлэн батлах тухай” А/164 дүгээр захирамжаар “Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газрын дүрэм”-ийг баталсан. Тус дүрмээр *“Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газар нь Монгол Улсын хууль, тогтоомж, Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, нийслэлийн хөгжлийн урт, дунд, богино хугацааны бодлого, нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн нийгэм, эдийн засгийн зорилтууд болон Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Нийслэлийн Засаг даргаас агаар, орчны чанарыг тодорхойлох, хяналт, шинжилгээ, судалгаа хийх, бохирдуулагч эх үүсвэрүүдээс байгаль орчин, иргэдийн эрүүл мэндэд учирч буй сөрөг нөлөөллийг бууруулах, дэвшилтэт шинэ технологийг нэвтрүүлэх талаар баримтлах бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах үндсэн чиг үүрэг бүхий Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг мөн”* гэж баталжээ.

Тус газар нь 5290031 регистрийн дугаартай, Төрийн сан банкинд үндсэн үйл ажиллагаа, нэмэлт санхүүжилт, барьцаа хөрөнгө, хөрөнгө оруулалт гэсэн данснуудаар бэлэн бус төлбөр тооцоог хийж байна.

Шалгалтад хамрагдах хугацаанд нэгдүгээр гарын үсгийг НАОБТГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Ганболд (2023 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс 07 дугаар сарын 31-ний өдөр хүртэл), Б.Батшагай (2023 оны 07 дугаар сарын 31-ээс 2024 оны 06 дугаар сарын 15-ны өдөр хүртэл), Д.Даваажаргал (2024 оны 06 дугаар сарын 15-аас 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдөр хүртэл), Д.Мөнхбаатар (2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс 2024 оны 12 дугаар сарын 31), хоёрдугаар гарын үсгийг Ерөнхий нягтлан бодогч Б.Байгалмаа (2023 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс 2023 оны 10 дугаар сарын 31-ний өдөр хүртэл), М.Мөнхтулга (2023 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс 2024 оны 12 дугаар сарын 31) нар тус тус зурж хөрөнгө мөнгийг захиран зарцуулсан байна.

Өмнөх шалгалтын талаар:

НАОБТГ-ын 2023 оны санхүүгийн тайланд нийслэл дэх Төрийн аудитын газраас аудитыг хийж гүйцэтгэн Өөрчлөлтгүй дүгнэлт хүргүүлсэн байна. Аудитаар нийт 148,012.3 мянган төгрөгийн зөрчил илэрч, 3 албан шаардлага, 3 зөвлөмжийг өгсөн байна.

Илэрсэн зөрчлийг дурьдвал. Үүнд:

1. Нөөцлөх шаардлагагүй 14,480.0 мянган төгрөгийн бараа, материалыг бэлтгэж үр ашиггүй удаан хадгалсан.
2. Гадаад сургалт зохион байгуулж 106,400.0 мянган төгрөгийн төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан.
3. Анхан шатны баримтын бүрдэл дутуу 27,132.3 мянган төгрөгийн ажил гүйлгээ хийж

- данс бүртгэлд тусган, өмнөх оны аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй.
4. Үндсэн хөрөнгөд бүртгэлтэй автомашинууд хувийн хэрэггүй.
 5. Нярав бараа материалын агуулахын бүртгэл хөтлөөгүй.
 6. Үндсэн хөрөнгийн бүртгэлд газрын хэмжээг шинэчлэн бүртгээгүй.

НАОБТГ-ын 2024 оны санхүүгийн тайланд Нийслэл дэх Төрийн аудитын газраас аудитыг хийж гүйцэтгэн Хязгаарлалттай дүгнэлт хүргүүлсэн байна. Аудитаар нийт 4,194,199.6 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 3,944,912.4 мянган төгрөгийн 4 албан шаардлага, 249,287.2 мянган төгрөгийн зөвлөмж өгсөн.

Илэрсэн зөрчлийг дурьдвал. Үүнд:

1. Төсвийн шууд захирагч нь тайлант оны зарим худалдан авалтын захиалга хүсэлт цахим дэлгүүрт хүргүүлээгүй, аваагүй, бусад этгээдээс 498,845.2 мянган төгрөгийн бараа, үйлчилгээг худалдан авсан.
2. Сайжруулсан түлш хадгалах агуулах түрээслэх үйлчилгээнд тендер зарлалгүйгээр 13 иргэн, 7 аж ахуй нэгж байгууллагаас төсөвт өртгийн дээд хязгаараас давсан нийт 3,893,642.7 мянган төгрөгийн шууд худалдан авалт хийсэн.
3. Байгууллагын тээврийн хэрэгсэл хүрэлцэхгүйгээс хэлтэс албадын хувь хүний машинд 33,880.0 мянган төгрөгийн шатахууны талон олгож, жишиг нормоос илүү тооцсон, замын тооцооны хуудсыг хянан баталгаажуулаагүй, няравын олгосон шатахуунаар зарлагдсан.
4. Өмнөх оны урьдчилж төлсөн зардал 3,430.0 мянган төгрөгийг барагдуулаагүй, авлагын үлдэгдэл 5,000.0 мянган төгрөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй.
5. Өр төлбөрийн үлдэгдэл 8,959.7 мянган төгрөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй.
6. ТБОНӨХБАҮХАТХууль тогтоомжтой холбоотой хэрэгжилтийг шалгахад тайлант онд батлагдсан ХАА-ны төлөвлөгөө, гэрээ, гүйцэтгэлийн тайланг цахим систем (www.tender.gov.mn)-д ил тод мэдээлээгүй, байршуулаагүй байна.

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ХАМРАХ ХҮРЭЭ

Санхүүгийн хяналт шалгалт хийх үндэслэл, бүрэлдэхүүн

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10 “Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх”, 69 дүгээр зүйлийн 69.1. “Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна.”, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”, нийслэлийн Дотоод аудитын газрын “Аудит, хяналт шалгалтын 2025 оны төлөвлөгөө”, нийслэлийн Засаг даргын баталсан 08 дугаар удирдамжийн дагуу нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газрын 2023, 2024 оны үйл ажиллагаанд Аудит хяналт шалгалтын хэлтсийн ахлах дотоод аудитор, санхүү хяналт шалгалтын улсын ахлах байцаагч Д.Мөнхханд, дотоод аудитор Г.Баярмаа нар 2025 оны 05 дугаар сарын 08-ны өдрөөс эхлэн ажлын 15 хоногт хийж гүйцэтгэлээ.

Хамрах хүрээ

Санхүүгийн хяналт шалгалтад тус газрын 2023, 2024 оны дараах үйл ажиллагааг хамруулан шалгалаа. Үүнд:

- Санхүү, төсөв, өмч, нягтлан бодох бүртгэлийн холбогдолтой хууль, тогтоомж, түүнийг үндэслэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан заавар, журмын хэрэгжилт;

- Худалдан авалттай холбоотой үйл ажиллагаа;
- Байгууллагын дотоод журам, удирдлагын тушаал, бусад байгууллага хувь хүнтэй байгуулсан гэрээ, хэлцэл нь хууль эрх зүйн үндэслэлтэй хийгдсэн эсэх, тэдгээрийн хэрэгжилт;
- Батлагдсан төсөв, зорилтот түвшин түүний зарцуулалт, өөрийн орлогын төлөвлөгөө, биелэлтийн байдал;
- Тус байгууллагын бүтэц орон тоо, цалин хөлсний тогтоолт олгосон байдал;
- Өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, зарцуулалт, олж бэлтгэсэн байдал;
- Санхүүгийн үйл ажиллагааны үр дүн, үр ашгийн байдал;
- Дээд шатны төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэгийн зарцуулалт;
- Хөрөнгө оруулалтын ашиглалт, зарцуулалт;
- Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, баримтын бүрдүүлэлт, боловсруулалт, санхүүгийн мэдээ, тайлан гаргалтын байдал;
- Гадаад, дотоодын байгууллага, иргэдээс өгсөн зээл, тусламжийн хөрөнгийн зарцуулалт, ашиглалтын байдал;
- Татвар, нийгмийн даатгалын шимтгэл;
- Байгууллагын нягтлан бодогчийн хууль тогтоомжид заасан үүргийн биелэлтийг хамруулан шалгалаа.

Үндсэн үйл ажиллагааны талаар

Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газар нь Эрхэм зорилгоо “Агаар, орчны бохирдлыг бууруулахад чиглэсэн байгальд ээлтэй, үр ашигтай хэрэглээг нэмэгдүүлэх болон байгаль орчин, үйлдвэр, технологийн хүрээнд хяналт тавих замаар иргэдийн эрүүл, аюулгүй амьдрах орчныг бүрдүүлэхэд оршино” гэж тодорхойлжээ.

Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газар нь дараах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:

- Агаар, орчны бохирдлыг бууруулах арга хэмжээг нийслэлийн нутаг дэвсгэрт зохион байгуулах;
- Байгальд ээлтэй, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж, агаар, орчны бохирдлын багасгах, бохирдуулагч бодисын хаягдлыг бууруулах;
- Агаарын чанарын улсын хяналт-шинжилгээний сүлжээний нийслэл дэх нэгжийн тасралтгүй ажиллагааг хангах;
- Агаар, орчны чанарын хяналт-шинжилгээний сүлжээг өргөтгөх, шилжүүлэх, өөрчлөн байршуулах талаар санал боловсруулж, төрийн захиргааны төв байгууллагад танилцуулж шийдвэрлүүлэх;
- Агаар, орчны бохирдуулагч эх үүсвэрийн нэгдсэн бүртгэл тооллогыг жил бүр зохион байгуулах;
- Улаанбаатар хотын агаар, орчны бохирдлын хэмжилт хийх, судалгаа гаргах, олон нийтийн оролцоо, үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх;
- Агаар, орчны бохирдлыг бууруулах зорилгоор байгальд ээлтэй, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэхэд нь иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх;
- Байгальд ээлтэй түлш үйлдвэрлэгч аж ахуйн нэгжүүдийн түлшний үйлдвэрлэлийг холбогдох хууль тогтоомжийн дагуу дэмжих;
- Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуйн нэгж,

байгууллагын халаалтын зуухны ашиглалт, түлшний зарцуулалтад хяналт тавих ажлыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах;

- Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийн дагуу орчны агаарын чанар болон агаар бохирдуулах эх үүсвэрийн хаягдал хийг тодорхойлох хэмжилтийн ажлыг холбогдох журмын дагуу зохион байгуулах;
- Агаарын чанарын 7 хоногийн мэдээг нэгтгэн баталгаажуулж, холбогдох байгууллагад хүргүүлэх;
- Агаар орчны чанарт нөлөөлж болзошгүй үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын дотоод орчны агаар, орчны чанарт хэмжилт хийх, үнэлгээ, зөвлөмж өгөх;
- Агаар, орчны бохирдолтой тэмцэх үйл ажиллагаанд олон нийтийн оролцоо, үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлж, эрүүл амьдрах зөв дадлыг төлөвшүүлэх талаар идэвх, санаачилгатай ажилласан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах;
- Төрийн хяналт шалгалтын тухай хуульд заасан нийтлэг бүрэн эрхийг хэрэгжүүлж, агаар, байгаль орчны тухай хууль тогтоомж, дүрэм, журам, стандарт, хэм хэмжээ, шийдвэрийн биелэлтийг хангуулах;
- Хүрээлэн буй орчинд хаягдах хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээнд хяналт тавих
- Бүх төрлийн хатуу түлшний үйлдвэрлэл, савлалт, хадгалалтад төрийн нэрийн өмнөөс хяналт, шалгалт хийх, дүгнэлт гаргах, зөрчлийг арилгуулах;
- Зөрчлийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулж, зөрчил гаргасан иргэн, хуулийн этгээдэд хуульд заасан журмын дагуу торгууль ногдуулах, акт тавих, албан шаардлага, мэдэгдэл, зөвлөмж хүргүүлэх, зөрчлийн хэрэг үүссэн тохиолдолд Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн дагуу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох;

Бүтэц, орон тооны талаар:

Нийслэлийн Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн “Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар татан буугдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” А/1649 дугаар захирамжийн хавсралтаар Агаар, орчны бохирдолтой тэмцэх газрын зохион байгуулалтын бүтцийг Захиргаа, санхүүгийн хэлтэс, Бодлогын хэрэгжилтийн хэлтэс, Агаарын чанарын хэмжилт зохион байгуулалтын хэлтэс, Хяналт шалгалтын хэлтэс гэсэн 4 хэлтэс, 48 хүртэл, үүнээс Дарга 1, нийт 49 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулахаар баталсан байна.

НАОБТГ-ын даргын 2023 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн “Байгууллагын зохион байгуулалтын бүтэц, албан тушаалын жагсаалтыг батлах тухай” А/29 дугаар тушаалын хавсралтаар Дарга 1, Захиргаа, санхүүгийн хэлтэс 10, Бодлогын хэрэгжилтийн хэлтэс 21, Агаар чанарын хэмжилт, зохион байгуулалтын хэлтэс 9, Хяналт, шалгалтын хэлтэс 7, нийт 48 албан тушаалтны бүрэлдэхүүнтэй ажиллахаар бүтэц, орон тоог баталсан байна.

Тус газар нь 2023 онд Дарга 1, Захиргаа, санхүүгийн хэлтэс 9, Бодлогын хэрэгжилтийн хэлтэс 16, Агаар чанарын хэмжилт, зохион байгуулалтын хэлтэс 9, Хяналт, шалгалтын хэлтэс 5, нийт 40, 2024 онд Дарга 1, Захиргаа, санхүүгийн хэлтэс 10, Бодлогын хэрэгжилтийн хэлтэс 18, Агаар чанарын хэмжилт, зохион байгуулалтын хэлтэс 9, Хяналт, шалгалтын хэлтэс 7, нийт 45 албан хаагчийн бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.

Хүснэгт 1.

Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газрын
зохион байгуулалтын бүтэц, албан тушаалын жагсаалт

№	Албан тушаалын нэр	Ангилал, зэрэглэл	Орон тоо	2023 он	2024 он
Удирдлага /1/					
1	Дарга	ТЗ-3	1	1	1
Захиргаа, санхүүгийн хэлтэс /9/					
2	Хэлтсийн дарга	ТЗ-4	1		1
3	Хүний нөөц, хуулийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн	ТЗ-7	1	1	1
4	Хяналт шинжилгээ, үнэлгээ хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн	ТЗ-8	1	1	1

5	Төлөвлөгөө, тогтоол шийдвэрийн биелэлт хариуцсан мэргэжилтэн	T3-8	1	1	1
6	Сургалт, олон нийттэй харилцах асуудал хариуцсан мэргэжилтэн	T3-8	1	1	1
7	Дотоод хяналт хариуцсан мэргэжилтэн	T3-8	1	1	1
8	Хуулийн зөвлөх, гэрээ хариуцсан ажилтан	TY-7	1	1	1
9	Үйл ажиллагаа хариуцсан менежер	TY-7	1	1	1
10	Өргөдөл гомдол, шуурхай асуудал хариуцсан ажилтан	TY-6	1	1	1
11	Архив бичиг хэргийн эрхлэгч	TY-5	1	1	1
Бодлогын хэрэгжилтийн хэлтэс /21/					
12	Хэлтсийн дарга	T3-4	1	1	1
13	Гэр хорооллоос үүдэлтэй агаарын бохирдол хариуцсан ахлах мэргэжилтэн	T3-7	1		
14	Түлшний бодлого хариуцсан ахлах мэргэжилтэн	T3-7	1	1	1
15	Хэсэгчилсэн дулаан хангамж хариуцсан мэргэжилтэн	T3-8	1	1	1
16	Авто тээврийн бодлогын хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн	T3-8	1		1
17	Төлөвлөлт гүйцэтгэл, тооцоо судалгаа хариуцсан мэргэжилтэн	T3-8	1		
18	Агаарын бохирдлын нөлөөлөл, тархалтын загварчлал хариуцсан мэргэжилтэн	T3-8	1	1	1
19	Дотоод орчны агаарын бохирдол хариуцсан мэргэжилтэн	T3-8	1	1	1
20	Шингэрүүлсэн хий, сайжруулсан түлшний асуудал хариуцсан мэргэжилтэн	T3-8	1	1	
21	Барилгын дулаан алдагдал, хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэн	T3-8	1	1	1
22	Байгальд ээлтэй технологи, сэргээгдэх эрчим хүч хариуцсан мэргэжилтэн	T3-8	1	1	1
23	Хяналт, зохицуулалтын ажилтан	TY-4	10	8	10
Агаарын чанарын хэмжилт, зохион байгуулалтын хэлтэс /9/					
24	Хэлтсийн дарга	T3-4	1	1	1
25	Хөдөлгөөнт эх үүсвэрийн хэмжилт хариуцсан ахлах мэргэжилтэн	T3-7	1	1	1
26	Агаар бохирдуулах эх үүсвэрийн хэмжилт хариуцсан мэргэжилтэн	T3-8	1	1	1
27	Агаарын чанарын хяналт хариуцсан мэргэжилтэн	T3-8	1	1	1
28	Орчны хэмжилт хариуцсан мэргэжилтэн	T3-8	1	1	1
29	Дүн шинжилгээ, төсөл, хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн	T3-8	1	2	1
30	Оператор, техникч	TY-5	3	2	3
Хяналт, шалгалтын хэлтэс					
31	Хэлтсийн дарга, байгаль орчны улсын ахлах байцаагч	T3-4	1	1	1
32	Байгаль орчны улсын ахлах байцаагч	T3-6	1		
33	Байгаль орчны улсын байцаагч	T3-7	6	4	6
НИЙТ			49	40	45

Санхүүгийн үйл ажиллагааны талаар

Санхүүгийн тайлангийн талаар:

НАОБТГ нь 2023 оны жилийн эцсийн байдлаар санхүүгийн байдлын тайланд нийт 4,922,577.7 мянган төгрөгийн, 2024 онд нийт 4,990,684.6 мянган төгрөгийн хөрөнгийн үлдэгдлийг тус тус тайлагнасан байна. 2024 онд нийт хөрөнгө өмнөх оноос 68,106.9 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2

Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

(мянган төгрөг)

д/д	Балансын үзүүлэлт	2023.12.31	2024.12.31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	373,068.9	573,760.7
2	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	9,600.1	109,009.8
3	Кассанд байгаа бэлэн мөнгө	640.3	
4	Төрийн сангийн харилцах-барьцаа данс	8,959.6	109,009.8
5	АВЛАГА	794.5	11,854.8
6	Төлбөртэй үйлчилгээний авлага	794.5	6,854.8
7	Байгууллагаас авах авлага		5,000.0
8	УРЬДЧИЛГАА	3,430.0	3,430.0
9	Урьдчилж гарсан зардал	3,430.0	3,430.0
10	БАРАА МАТЕРИАЛ	359,244.4	449,466.1
11	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,549,508.8	4,416,923.9

12	Биет хөрөнгө	2,848,117.4	2,604,175.1
13	Биет бус хөрөнгө	1,701,391.4	1,812,748.8
14	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	4,922,577.7	4,990,684.6
15	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	59,592.7	118,130.3
16	Богино хугацаат өр төлбөр	59,592.7	118,130.3
17	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,862,985.0	4,872,554.3
18	Засгийн газрын оролцоо	4,862,985.0	4,872,554.3
19	Засгийн газрын оруулсан капитал	2,653,359.2	2,653,359.2
20	Өмч: -төрийн	2,653,359.2	2,653,359.2
21	Хуримтлагдсан үр дүн	2,209,625.8	2,219,195.1
22	Өмнөх үеийн үр дүн	2,275,471.1	2,275,471.1
23	Тайлант үеийн үр дүн	(65,845.3)	(56,276.0)
24	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,922,577.7	4,990,684.6

Мөнгөн хөрөнгийн талаар:

Тайлант 2023 онд 9,600.1 мянган төгрөгийн, 2024 онд 109,009.8 мянган төгрөгийн үлдэгдэл тайлагнасан байна. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 99,409.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь хөрөнгө оруулалтын барьцаа хөрөнгө нэмэгдсэнтэй холбоотой байна.

Авлагын талаар:

Тайлант 2023 онд 794.5 мянган төгрөгийн, 2024 онд 11,854.8 мянган төгрөгийн үлдэгдэл тайлагнасан байна. Авлага дансны үлдэгдэл 11,060.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь татвар, НДШ-ийн илүү төлөлт 6,854.8 мянган төгрөг, шатахууны авлага 5,000.0 мянган төгрөг байгаа нь нөлөөлсөн байна.

Урьдчилж гарсан зардлын талаар:

Урьдчилгаа дансны үлдэгдэл 3,430.0 мянган төгрөг 2020 онд үүссэн Монголын сайтуудын холбоо ТББ-аар хийлгэсэн арга хэмжээний зардал байна.

Бараа материалын талаар:

НАОБТГ нь 2023 онд 250,000.0 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авч, 188,970.3 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулан, 359,244.3 мянган төгрөгийн бараа материал үлдэгдэл, 2024 онд 1,636,878.5 мянган төгрөгийн бараа материалыг худалдан, хандиваар 1,164.0 мянган төгрөгийн бараа материалыг авч, 1,514,503.3 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулан, 34,533.3 мянган төгрөгийн бараа материалыг акталж устган, 449,466.0 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдэл тайлагнасан байна.

Хүснэгт 3

Бараа материалын тайлан

(мянган төгрөг)

д/д	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн		Хасагдсан		Эцсийн үлдэгдэл
			Худалдан авсан	Хандив	Худалдсан	Актлаж, устгасан	
		2023					
1	Тусгай зориулалтын материал	68,314.0	36,105.0		23,425.0		80,994.0
2	Бичиг хэргийн материал	6,523.0	21,933.2		20,415.7		8,040.5
3	Аж ахуйн материал	825.0	7,057.0		3,538.0		4,344.0
4	Сэлбэг хэрэгсэл	196,681.5	148,637.4		109,437.4		235,881.5
5	Түлш шатах тослох материал	9,110.0	25,110.0		21,060.0		13,160.0
6	Бусад хангамжийн материал	16,762.3	11,156.4		11,094.4		16,824.3
Дүн		298,215.8	249,999.0		188,970.5		359,244.3
		2024					
1	Тусгай зориулалтын материал	80,994.0	102,267.0		60,947.0	29,564.0	92,750.0
2	Бичиг хэргийн материал	8,040.5	20,144.1		21,522.8	2,589.4	4,072.4
3	Аж ахуйн материал	4,344.0	8,986.4		3,547.0		9,783.3
4	Сэлбэг хэрэгсэл	235,881.5	146,229.8		77,383.5		304,727.8
5	Түлш шатах тослох материал	13,160.0	38,800.0	1,164.0	47,400.0		5,724.0
6	Барилга засварын материал		39,467.4		39,467.4		
7	Бусад хангамжийн материал	16,824.3	1,279,820.1		1,261,855.9	2,380.0	32,408.5
Дүн		359,244.3	1,635,714.8	1,164.0	1,512,123.6	34,533.4	449,466.0

НАОБТГ-ын даргын 2024 оны 08 дугаар сарын 24-ний өдрийн “Хангамжийн хөрөнгө данс бүртгэлээс хасах тухай” А/60 дугаар тушаалаар 43 нэр төрлийн 34,533.43 мянган төгрөгийн үнэ бүхий эргэлтийн бус хангамжийн материалыг данс бүртгэлээс хассан байна.

Үндсэн хөрөнгийн талаар:

НАОБТГ нь 2023 онд 3,174.4 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг худалдан, 40,875.0 мянган төгрөгийн авто тээврийн хэрэгсэл, 410,992.2 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 8,618.6 мянган төгрөгийн тавилга хэрэгсэл, 2,970.0 мянган төгрөгийн программ хангамжийг хандиваар авч бүртгэн, нийт 9,578,262.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэл тайлагнасан байна.

НАОБТГ нь 2024 онд 15,532.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 3,700.0 мянган төгрөгийн тавилга хэрэгсэл, 37,000.0 мянган төгрөгийн бусад үндсэн хөрөнгө, 114,204.4 мянган төгрөгийн программ хангамжийг худалдан, 39,047.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг шилжүүлэн авч бүртгэн, нийт 9,787,750.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэл тайлагнасан байна.

Хүснэгт 4

Үндсэн хөрөнгийн тайлан

(мянган төгрөг)

Д/Д	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн			Эцсийн үлдэгдэл
			Худалдан авсан	Шилжүүлсэн	Хандив	
			2023 он			
1	Барилга байгууламж	2,531,624.1				2,531,624.1
2	Авто тээврийн хэрэгсэл	260,636.8			40,875.0	301,511.8
3	Тоног төхөөрөмж	3,771,862.6	3,174.4		410,992.2	4,186,029.2
4	Тавилга хэрэгсэл	41,943.2			8,618.6	50,561.8
5	Газар эзэмших эрх	1,728,761.2				1,728,761.2
6	Бусад үндсэн хөрөнгө	454,903.6				454,903.6
7	Программ хангамж	158,641.2			2,970.0	161,611.2
8	Бусад биет хөрөнгө	163,259.5				163,259.5
Дүн		9,111,632.2	3,174.4	0.0	463,455.8	9,578,262.4
		2024 он				
1	Барилга байгууламж	2,531,627.1				2,531,627.1
2	Авто тээврийн хэрэгсэл	301,511.8				301,511.8
3	Тоног төхөөрөмж	4,186,029.3	15,532.5	39,047.8		4,240,609.6
4	Тавилга хэрэгсэл	50,561.8	3,700.0			54,261.8
5	Газар эзэмших эрх	1,728,761.2				1,728,761.2
6	Бусад үндсэн хөрөнгө	454,903.6	37,000.0			491,903.6
7	Программ хангамж	161,611.2	114,201.4			275,812.6
8	Бусад биет хөрөнгө	163,259.5				163,259.5
Дүн		9,578,265.5	170,433.9	39,047.8	0.0	9,787,747.2

НӨХГ-ын даргын 2023 оны 05 дугаар сарын 23-ний өдрийн “Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын эргэлтийн бус хөрөнгийг балансаас баланст шилжүүлэх тухай” А/96 дугаар тушаалаар Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй 422,580.8 мянган төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газрын баланст шилжүүлж, данс бүртгэлээс хасахыг нийслэлийн Мэргэжлийн хяналтын газарт зөвшөөрсүгэй гэж шийдвэрлэсэн байна.

НАОБТГ-ын даргын 2023 оны 05 дугаар 31-ний өдрийн “Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын эргэлтийн бус хөрөнгийг балансаас баланст шилжүүлэх тухай” А/59 дүгээр тушаалаар Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй 422,580.8 мянган төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг НӨХГ-аас шилжүүлэн авч данс бүртгэлд тусгасан.

НАОБТГ-ын даргын 2024 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн “Хөрөнгө бүртгэх тухай” А/74 дүгээр тушаалаар 23,850.0 мянган төгрөгийн үнэ бүхий суурин компьютер, 15,197.8 мянган төгрөгийн үнэ бүхий принтерийг данс бүртгэлд бүртгэсэн байна.

НАОБТГ-ын даргын 2024 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн “Эд хөрөнгө бүртгэх тухай” А/94 дугаар тушаалаар 8,400.0 мянган төгрөгийн үнэ бүхий архивын шүүгээ, 2,690.0 мянган төгрөгийн үнэ бүхий таблетыг данс бүртгэлд бүртгэсэн байна.

НАОБТГ-ын даргын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн “Байгууллагын үндсэн эд хөрөнгө бүртгэх тухай” А/131 дугаар тушаалаар 109,010.0 мянган төгрөгийн үнэ бүхий Агаар

бохирдуулагч эх үүсвэрийн мэдээллийн сангийн өгөгдөл, үйл ажиллагааг уялдуулах, эрчимжүүлэх, нэгдсэн системд шилжих эх үүсвэрийн тооллогын программ, 191.4 мянган төгрөгийн домайн хаяг, 5,000.0 мянган төгрөгийн үнэ бүхий цахим хуудсыг данс бүртгэлд бүртгэсэн байна.

Төсвийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтын талаар:

НИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн “Нийслэлийн 2023 оны төсөв батлах тухай” 115 дугаар тогтоолоор НАОБТГ-ын үйл ажиллагааны зардал 1,248,578.6 мянган төгрөг, “Утаагүй Улаанбаатар хөтөлбөр”-ийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний зардал 38,167,760.0 мянган төгрөг, нийт 39,416,338.6 мянган төгрөгийн төсвийг зарцуулах эрхийг олгож баталсан байна. НИТХ-ын 2023 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн “Нийслэлийн 2023 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай” 85 дугаар тогтоолоор НАОБТГ-ын үйл ажиллагааны зардал 1,531,298.3 мянган төгрөг, Сайжруулсан түлшний тээвэрлэлт, хадгалалт, хяналт шалгалтын зардал, борлуулалтын урамшуулалд 38,167,760.0 мянган төгрөг, нийт 39,699,058.3 мянган төгрөгийн төсвийг зарцуулахаар баталсан.

НИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн “Нийслэлийн 2024 оны төсөв батлах тухай” 122 дугаар тогтоолоор НАОБТГ-ын үйл ажиллагааны зардал 1,741,255.0 мянган төгрөг, Сайжруулсан түлшний тээвэрлэлт, хадгалалт, хяналт шалгалтын зардал, борлуулалтын урамшуулалд 49,807,760.0 мянган төгрөг, нийт 51,549,015.0 мянган төгрөгийг зарцуулахаар төсвийг баталсан байна. НИТХ-ын 2024 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн “Нийслэлийн 2024 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай” 88 дугаар тогтоолоор НАОБТГ-ын үйл ажиллагааны зардал 1,889,755.0 мянган төгрөг, Сайжруулсан түлшний тээвэрлэлт, хадгалалт, хяналт шалгалтын зардал, борлуулалтын урамшуулалд 49,807,760.0 мянган төгрөг, нийт 51,697,515.0 мянган төгрөгийг зарцуулахаар төсвийг баталсан байна.

Хүснэгт 5

Төсвийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалт

(мянган төгрөг)

д/д	Үзүүлэлт	2023 он			2024 он		
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	39,534,619.0	33,050,521.0	6,484,098.0	51,697,515.0	35,984,069.7	15,713,445.2
2	Урсгал зардал	39,534,619.0	33,050,521.0	6,484,098.0	51,697,515.0	35,984,069.7	15,713,445.2
3	Бараа, ажил үйлчилгээний зардал	39,534,619.0	33,050,521.0	6,484,098.0	51,672,413.5	35,959,296.2	15,713,117.3
4	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	911,319.7	812,241.1	99,078.6	1,310,647.7	987,751.8	322,895.9
5	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	116,031.9	106,120.2	9,911.7	169,375.1	125,901.2	43,473.9
6	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	72,770.5	64,458.0	8,312.5	79,247.2	55,517.3	23,729.9
7	Хангамж, бараа материалын зардал	22,484,540.3	18,444,026.6	4,040,513.7	32,074,375.2	21,717,521.8	10,356,853.4
8	Норматив зардал	4,500.0	3,200.0	1,300.0	16,800.0	16,270.0	530.0
9	Эд хогшил, урсгал засварын зардал	161,039.7	103,318.4	57,721.3	174,447.7	149,361.3	25,086.4
10	Томилолт, зочны зардал	6,390.0		6,390.0	1,980.0	0.0	1,980.0
11	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,226,666.9	5,927,389.8	299,277.1	8,314,780.6	5,753,547.3	2,561,233.2
12	Бараа үйлчилгээний бусад зардал	9,541,360.0	7,581,916.9	1,959,443.1	9,530,760.0	7,153,425.4	2,377,334.6
13	Урсгал шилжүүлэг	10,000.0	7,849.6	2,150.4	25,101.5	24,773.6	327.9
14	Бусад урсгал шилжүүлэг	10,000.0	7,849.6	2,150.4	25,101.5	24,773.6	327.9
15	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	39,534,619.0	33,052,375.1	6,482,243.9	51,697,515.0	35,983,429.4	15,714,085.6
16	Орон нутгийн төсвөөс санхүүжих	39,519,619.0	33,035,521.0	6,484,098.0	51,682,515.0	35,955,635.1	15,726,879.9
17	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	15,000.0	16,854.1	-1,854.1	15,000.0	27,794.3	-12,794.3

2023 онд Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг орон нутгийн төсвөөс 39,519,619.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 15,000.0 мянган төгрөгийг бүрдүүлэхээр төсвийг баталж, гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 33,035,521.0

мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагааны орлогоос 16,854.2 мянган төгрөгийг бүрдүүлэн, үйл ажиллагаандаа 33,050,521 мянган төгрөгийг зарцуулж, орон нутгийн төсөвт 1,213.8 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлж, харилцах дансанд 640.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй үлдсэн байна.

2024 онд төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 60,369,125.3 мянган төгрөг, нийт зарлагыг 60,369,125.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид санал хүргүүлснээр төсвийн төслийн саналаас 8,820,110.3 мянган төгрөгөөр бууруулж, 51,549,015.0 мянган төгрөгөөр баталсан байна. Тайлант оны сүүлийн хагас жилд тодотгол хийн, цалин хөлсийг 148,500.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр орон нутгийн төсвөөс 51,682,515.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 15,000.0 мянган төгрөгийг олохоор баталжээ. Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 35,955,635.1 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 27,794.3 мянган төгрөг, нийт 35,983,429.4 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 35,970,635.0 мянган төгрөгийг зарцуулан, давсан орлогын 12,794.3 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 6

2024 оны зардлын хэмнэлт

(мянган төгрөг)

д/д	Төсөл, арга хэмжээ	Батлагдсан төсөв	Олгосон санхүүжилт	Хэмнэлт	Тайлбар
1	Нийслэлийн 2024 оны төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх сайжруулсан шахмал түлш тээвэрлэх	32,000,000.0	21,660,194.8	10,339,805.2	Таван толгой түлш ХХК-ийн 2024 оны бүтээгдэхүүн үйлдвэрлэх төлөвлөгөөний дагуу тус байгууллага нь 6, 7 дугаар сард амарч сайжруулсан шахмал түлшний тээвэрлэлт хийгдээгүй тул 2024 оны төсөв хэмнэгдсэн байна.
2	Сайжруулсан шахмал түлш нөөцлөх, агуулах түрээслэх	7,680,000.0	5,722,095.6	1,957,904.4	Өмнөх жилүүдэд 120.000 тонн сайжруулсан шахмал түлш нөөцөлсөн. 2024-2025 оны өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хүрээнд 100.000 тонн түлш нөөцөлсөн тул агуулахын түрээсийн зардал хэмнэгдсэн байна.
3	Сайжруулсан шахмал түлш борлуулсаны зардал	9,526,760.0	7,150,940.4	2,375,819.6	Өмнө жилүүдэд нийслэлд 650 борлуулалтын цэг ажлуулдаг байсан бөгөөд 2024-2025 оны халаалтын улиралд 582 цэг ажиллуулсан тул хэмнэлт гарсан.

Нэмэлт санхүүжилтийн талаар:

2023 онд БОАЖЯ-аас гэрээт ажилчдын цалинд 406,321.1 мянган төгрөг, агаарын чанарыг сайжруулах бүсэд хамрагдах 95 хороонд ажиллаж байсан орон тооны бус ажилтнуудын урамшуулалд 106,400.0 мянган төгрөг, нийт 512,721.1 мянган төгрөгийн санхүүжилт олгож, 511,614.3 мянган төгрөгийг зарцуулан, 1,106.8 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна. 2024 онд БОАЖЯ-аас 1,234,905.0 мянган төгрөг, нийслэлийн ЗД-ын нөөцөөс 179,355.0 мянган төгрөг, нийт 1,414,260.0 мянган төгрөгийн санхүүжилт олгож, хөтөлбөр, арга хэмжээнд 1,414,260.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Хүснэгт 7

Нэмэлт санхүүжилтийн дансны зарцуулалт

(мянган төгрөг)

д/д	Үзүүлэлт	Гүйцэтгэл	
		2023 он	2024 он
1	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	512,721.1	1,414,260.0
2	Урсгал зардал	512,721.1	1,414,260.0
3	Бараа, ажил үйлчилгээний зардал	511,614.2	1,414,260.0
4	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	405,214.2	1,369,260.0
5	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр, хураамж	405,214.2	1,369,260.0
6	Бараа үйлчилгээний бусад зардал	106,400.0	45,000.0
7	Бараа үйлчилгээний бусад зардал	106,400.0	45,000.0
	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,106.9	
	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,106.9	

8	Зардлыг санхүүжүүлэн эх үүсвэр	512,721.1	1,414,260.0
9	Нэмэлт санхүүжилтийн орлого	512,721.1	1,414,260.0
10	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	512,721.1	1,414,260.0

2023 онд гэрээт ажилчдын цалинд 405,214.3 мянган төгрөг, “Аялалын гүүр” ХХК-руу агаарын чанарыг сайжруулах бүсийн хороодод идэвхи санаачилгатай, ажлын үр дүнгээрээ шалгарсан орон тооны бус гэрээт ажилтуудад гадаад аялал зохион байгуулах үйлчилгээ үзүүлэх зардалд 106,400.0 мянган төгрөгийг зарлага болгон, 1,106.8 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

2024 онд Угаарын хий мэдрэгчийн зардалд 1,234,905.0 мянган төгрөг, хяналтын цэгт ажиллах зөөврийн 2 сууцны зардалд 45,000.0 мянган төгрөг, сэрэмжлүүлэг, сурталчилгаа холбоотой видео контент, шторк, гарын авлага тараах материалын зардалд 86,355.0 мянган төгрөг, world clean up IV нөлөөллийн аян арга хэмжээний зардалд 48,000.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Худалдан авах ажиллагааны талаар

НАОБТГ нь Улс, нийслэлийн төсвийн хөрөнгөөр болон өөрийн урсгал зардлаар 2023 онд 5 төсөл арга хэмжээг 24,449,081.1 мянган төгрөг, 2024 онд 8 төсөл, арга хэмжээг 28,236,335.8 мянган төгрөгөөр санхүүжүүлсэн байна.

Хүснэгт 8

Худалдан авах ажиллагаа

(мянган төгрөг)

д/д	Ажлын нэр	Байгууллагын нэр	Төсөвт өртөг	Гэрээний хугацаа	Гэрээний дүн	Олгосон санхүүжилт	Тайлбар
Улсын болон Нийслэлийн төсвийн хөрөнгөөр санхүүжих хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ							
2023 он							
1	Замын хөдөлгөөний зорчих хурдны судалгаа хийх	"Мэргэжлийн социологичдын холбоо" ТББ	30,000.0		29,999.0	29,999.0	НАОБТГ зохион байгуулсан
2	Сайжруулсан шахмал түлш тээвэрлэх төсөл, арга хэмжээ		22,440,000.0		20,185,349.5	18,413,997.1	
3	Дүн				20,215,348.5	18,443,996.1	
2024 он							
4	Агаарын чанарыг сайжруулах бүсийн гэр хорооллын айл өрхүүдэд алсын зайн дамжуулагчтай угаарын хий мэдрэгч айл өрхүүдэд суурилуулах	"Интеллгент технологи" ХХК	1,300,000.0	2024.11.05-2024.12.05	1,299,900.0	1,234,905.0	НЗД-ын 2024 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн А/1015 дугаар захирамжаар НХААГ-т эрх шилжүүлсэн
5	Агаарын бохирдлыг бууруулах тоног төхөөрөмж	"Экоресурс" ХХК	2,000,000.0	2024.12.08-2024.12.30	1,892,000.0	94,600.0	НЗД-ын 2024 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн А/133 дугаар захирамжаар НХААГ-т эрх шилжүүлсэн
6	Сайжруулсан шахмал түлш тээвэрлэх төсөл, арга хэмжээ		32,000,000.0		28,224,887.9	21,660,194.7	НЗД-ын 2024 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн А/118 дугаар захирамжаар НХААГ-т эрх шилжүүлсэн
7	Дүн				31,416,787.9	22,989,699.7	
Урсгал зардлаар санхүүжих арга хэмжээ							
2023 он							
8	Суурин харуулын сэлбэг хэрэгсэл нийлүүлэх	"ИНТЕРСАЙНС" ХХК		2023.06.19-2023.08.04	50,000.0	50,000.0	